



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хот

“Ахмадаа сонсьё” арга хэмжээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1 “Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил”, “Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан “Ахмадаа сонсьё” арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан), Хороодын Засаг дарга (Н.Нямзав), (Б.Батзориг) нарт үүрэг болгосугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зарцуулах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах 656.490 (Зургаан зуун тавин зургаан мянга дөрвөн зуун ерэн) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 09 дүгээр сарын 27 ны өдрийн
11.1.20 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



**“АХМАДАА СОНСЪЁ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн
дарга:

Б.Цогжавхлан

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Гэрэлцолмон

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Энхтайван

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга

Б.Алтанцоож

Соёлын ордны захирал

Н.Нямзав

1 дүгээр хорооны Засаг дарга

Б.Батзориг

2 дугаар хорооны Засаг дарга

П.Нямжав


Ахмадын хорооны дарга

Нарийн бичгийн
дарга:

Ө.Амарзаяа

Нийгмийн хөгжлийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 09 дүгээр сарын 27 ны өдрийн
А/150 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**“АХМАДАА СОНСЪЁ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ**

№	Бараа	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Түлш /Хороо хооронд ахмадууд зөөх/	л	30	3480	104.400
2	Бензин-АИ92 /УБ хот болон зөрлөг хөдөөнөөс ахмад зөөх/	л	231	2390	552.090
Нийт дүн					656,490